



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**Хуулийн хэрэгжилтийг хангах
асуудлаар чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Нийгмийн халамжийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд халамжийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, төсөв, хөрөнгийг үр дүнтэй зарцуулах талаар доор дурдсан арга хэмжээг судлан хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т чиглэл болгосугай:

1.1. Хөдөлмөрт бэлтгэх сургалт, хөтөлбөрүүдийг эрчимжүүлэх, эмзэг бүлгийн иргэдийг хамруулах;

1.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангахад дэмжих;

1.3. Орон гэргүй иргэдийн түр хоноглох байр бий болгох;

1.4. Орон гэргүй, бусдын гэр түрээсэлж амьдардаг иргэдэд зориулсан гэрийг лизингээр авах үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг судлах;

1.5. Орон нутгаас нийслэлд шилжин суурьших хүн амын төвлөрлийг сааруулах, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх;

1.6. Иргэдэд гэр олгохдоо оршин суух газрын асуудлыг шийдвэрлэх шаардлага гарч байгааг анхаарах;

1.7. Нийгмийн халамжийн сангаас иргэдэд гэр олгох ажлыг хүртээмжтэй, шударга, ил тод, хяналттай болгох.

2. Засгийн газрын 2002 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан “Орон сууц хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлан мэдээ гаргах журам”, “Ахмад дайчдын орон сууцны тухай” Засгийн газрын 2007 оны 250 дугаар тогтоолын хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаар 2014 онд багтаан тус Байнгын хороонд танилцуулахыг Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.

**ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Р.БУРМАА